



ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

**МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ТАМГЫН ГАЗАР**

Ж.Самбуугийн гудамж 18, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот 15170, Утас: 26 15 44,
Цахим шуудан: info@supremecourt.mn

2024.09.04 № 05/4423
танай _____-ны № _____-т

Төсөл арга хэмжээний тухай

Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газраас зарласан УДШ/20240101002 дугаартай “Улсын дээд шүүхийн их засвар” /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/ төсөл, арга хэмжээний тендер оролцогчоос тендерийн баримт бичгийн ТШЗ-ын 18.1-д заасан борлуулалтын орлогын хэмжээг бууруулж өгөх талаар тодруулга ирүүлсэн байна.

Дээрх тендер шалгаруулалтын баримт бичгийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2023 оны А/259 дүгээр тушаалаар батлагдсан “Ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын жишиг баримт бичгийн дагуу үнэлгээний хороо боловсруулж, захиалагч баталсан ба мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д оролцогч нь захиалагчийн тогтоосон санхүүгийн чадавхын шаардлагыг хангасан байна гэж заасан байна.

Иймд тендерт оролцогч нь захиалагчийн баталсан тендер шалгаруулалтын баримт бичиг болон зураг төслийн дагуу тендерийг бэлтгэн ирүүлнэ.

ДАРГА



С.ЗАЯАДЭЛГЭР